



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

### Ажил дүгнэх байнгын комисс томилох, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2021 оны 374 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үүрэг бүхий ажил дүгнэх байнгын комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, "Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг хоёрдугаар, "Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн гүйцэтгэл"-ийг гуравдугаар, "Гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд"-ийг дөрөвдүгээр, "Тайлан бичих ерөнхий агуулгын дараалал, тайлагнах хугацаа"-г тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг Нийслэл, аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд танилцуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мөрдлөг болгон ажиллахыг Зоонозын өвчин судлалын төвийн дарга нар, Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээний албаны дарга (У.Нармандах)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (Э.Номин)-нд даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төвийн захирлын 2017 оны А/79 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



БАМГАЛАНБАЯР

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн  
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн  
2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн  
А/18... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ТТ35150 д.9092005

## АЖИЛ ДҮГНЭХ БАЙНГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Дэд захирал

Нарийн бичиг: Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээний албаны дарга

Гишүүд: Захиргааны албаны дарга  
Лавлагаа лабораторийн албаны дарга  
Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удидлагын албаны дарга  
Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны дарга  
Хүний нөөцийн менежер  
Санхүү, хангамж, нөөцийн албаны дарга  
Ариутгал халдваргүйтгэл, био үйлдвэрлэлийн албаны дарга



## НИЙСЛЭЛ, АЙМГИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВҮҮДИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хяналт шинжилгээ-үнэлгээний зорилго нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, хариуцлагыг дээшлүүлэх, мэргэжлийн удирдлагын төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийг сайжруулахад оршино.

1.2. Жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ, чанар, хугацаа, эцсийн үр дүнг тооцохдоо холбогдох хууль тогтоомж, тушаал, шийдвэрийг удирдлага болгож энэхүү журмыг мөрдөнө.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

2.1. Хяналт- шинжилгээ, үнэлгээнд аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүд хамрагдана.

2.2. Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв (ЗӨСТ)-үүдийн тухайн жилийн үйл ажиллагааг гүйцэтгэлийн хяналт үнэлгээний тайлан болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүгнэнэ. Үүнд:

2.2.1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилт (Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын албан даалгавар, Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар, төвийн Захирлын тушаал)

2.2.2. Хүний нөөцийн хөгжил, ил тод байдал;

2.2.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тандалт судалгаа;

2.2.4. Лабораторийн тусламж үйлчилгээ;

2.2.5. Эрдэм шинжилгээ, дотоод болон гадаадын сургалт, хамтын ажиллагаа;

2.3. Ажил дүгнэх комисс нь мэргэжлийн албадаас ирүүлсэн гүйцэтгэлийн хяналт үнэлгээний тайланд үндэслэн “Салбарын оны шилдэг хамт олон”-г шалгаруулна.

2.4. Ажил дүгнэх комисс нь мэргэжлийн албадаас ирүүлсэн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг нэгтгэн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг үндэслэн тушаал гаргаж баталгаажуулна.

### Гурав. Тайлагнах хугацаа, тавигдах шаардлага

3.1. Эрүүл мэндийн сайдын 2022 оны Журам шинэчлэн батлах тухай А/346 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт болон

байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацааны дагуу хамаарах асуудлын хүрээнд, батлагдсан загвараар биелэлтийг ирүүлнэ (дэлгэрэнгүйг 3 дугаар хавсралтад үзүүлэв).

3.2. Аймаг, Нийслэлийн ЗӨСТ-үүд нь жилийн эцсийн тайланг цахим хэлбэрээр жил бүрийн 11 дугаар сарын 25-ны өдрийн дотор, хэвлэмэл хэлбэрээр 12 дугаар сарын 05-ны дотор ЗӨСҮТ-д ирүүлнэ.

3.3. Тайланг MS Office Word программ дээр, үсгийн фонд Arial, хэмжээ 12, Times new roman фонтын 12-14 хэмжээтэй, мөр хоорондын зай 1.5 ашиглана. Хүснэгтэн мэдээллийн үсгийн хэмжээ 9-11 байхаар бичнэ.

3.4. Баримт бичгийн бичвэр нь түүний агуулгыг тодорхойлсон бүрдэл юм. Бичвэрийг хүүрнэх өгүүлбэрээр болон хүснэгтийн хэлбэрээр төрийн албан ёсны хэлээр бичнэ. Бичвэр нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Баримт бичгийн утгыг бүрэн, тодорхой, зөв илэрхийлсэн байх
- Хоёрдмол утгагүй
- Үгийн сонголт зөв байх
- Зөв бичих дүрэм, найруулга зүйн алдаагүй байх
- Албан ёсны тогтсон үг хэллэгтэй байх
- Агуулга, учир зүйн дэс дараалалтай байх

#### Дөрөв. Хяналт үнэлгээний зарчим

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ дараах зарчмыг баримтлана. Үүнд:

4.1.1. Шударга, хараат бус байх;

4.1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гарсан дүгнэлт, санал, зөвлөмж нь ил тод байх;

4.1.3. Хяналт- шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх;

4.1.4. Үр дүнд чиглэсэн байх.

#### Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

5.1. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан толорхойлсон тоон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ.

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

5.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно:

5.2.1.Зорилт арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь

5.2.2.Тавьсан зорилт, арга аэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр агрч эхэлж байгаа бол 70.0 хувь

5.2.3.Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь

5.2.4.Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30.0 хувь

5.2.5.Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг "0" хувь

5.3. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг тус бүрийн хэрэгжилтийг энэ журмын 5.1,5.2.-т заасан аргачлалын дагуу тооцох ба нийт зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн арифметик дунжийг тооцож, зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн ерөнхий үнэлгээ өгнө :

5.3.1."Үр дүнтэй" - зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

5.3.2."Тодорхой үр дүнд хүрсэн" - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь);

5.3.3."Эрчимжүүлэх шаардлагатай" - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь);

5.3.4."Үр дүнгүй" - зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0-30 хүртэл хувь);

5.4 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, үаалт тус бүрийн хэрэгжилтийн хувийг дараах аргачлалаар тооцно:

5.4.1."Бүрэн хэрэгжсэн" - холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

5.4.2. "Хэрэгжих шатанд" - тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, хөрөнгө санхүүтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

5.4.3. "Хэрэгжилт хангалтгүй" - тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, хөрөнгөтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

5.4.5. "Хэрэгжээгүй" - тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил боловсруулалтын шатанд байгаа, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);

5.4.6. "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй".

5.5. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн арифметик дунджийг тооцож, 5.3-т заасан ангилалд шилжүүлж, ерөнхий үнэлгээ өгнө.

5.6. Эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн 100 хүртэлх хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлнэ. Ерөнхий үнэлгээг тодорхойлохдоо жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0,05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд үржүүлэн дүгнэнэ:

5.7. Эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

"А" буюу "Маш сайн" бол 90-100 хувь (4.50-5.00 оноо)

"В" буюу "Сайн" бол 80-89.0 хувь (4.00-4.49 оноо)

"С" буюу "Хангалттай" бол 70-79.0 хувь (3.50-3.99 оноо)

"D" буюу "Дутагдалтай" бол 60-69.0 хувь (3.00-3.49 оноо)

"F" буюу "Хангалтгүй" бол 0-59.0 хувь (0.00-2.99 оноо)

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

6.1. Тухайн жилд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр "А" буюу "Маш сайн" үнэлгээ авсан ЗӨСТ-ийн даргыг нэг сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн шагналаар шагнаж урамшуулах тухай саналыг харьяалах Эрүүл мэндийн газарт албан бичгээр хүргүүлнэ. Мөнгөн урамшууллын зардлыг тухайн байгууллагын төсөвт тусгасан байна.

6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

## Долоо. Хариуцлага

7.1. Үнэлгээний дүнгээр “Дутагдалтай” болон “Хангалтгүй” гэж дүгнэгдсэн байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно

7.2. Энэхүү журмын 3 дахь бүлэгт заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, хугацаанд тайлагнаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн  
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн  
2024 оны .04. дүгээр сарын .05...-ны өдрийн  
А/18... дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ТТ35150.д.9092005

АЙМАГ, НИЙСЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН

ҮЗҮҮЛЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

№	Шалгуур үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Үр дүн
Нэг.Нийтлэг үзүүлэлт				
1.1	Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагдагсдын тоо			
1.2	Судалгаа, эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан			
1.3	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь			
1.4	Тухайн жилд тасралтгүй сургалтын кредитын шаардлага хангасан эмчийн хувь			
Хоёр.Өвөрмөц үзүүлэлт				
2.1	Идэвхтэй тандалтаар шинээр илрүүлсэн голомтын тоо			
2.2	Тухайн жилд төлөвлөгдсөн тандалтын гүйцэтгэлийн хувь			
2.3	Зоонозын халдварт өвчний өвчлөл (10 000 хүн амд)			
2.4	Лабораторийн оношийг баталгаажуулсан хувь			
2.5	Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулалтад хамруулсан хувь (нэр төрлөөр)			
2.6	Зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг лабораторийн шинжилгээнд хамруулсан хувь			
2.7	Эерэг сорьцын баталгаажилт			

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн  
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн  
2024 оны .04.. дүгээр сарын .05...-ны өдрийн  
118..... дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

ТТ35150 9092005

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Нийслэл, аймгийн ЗӨСТ-үүдэд хэрэгжүүлсэн хууль тогтоомжийн  
хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

### 1.1. Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэр албан даалгаврын хэрэгжилт

№	Хаанаас ирсэн	Тушаал, албан тоотын нэр	Албан бичгийн огноо, дугаар	Хэрэгжилтийг нотлох баримт бүрэн эсэх /тайлан, илтгэх хуудас гэх мэт/ хэрэв хэрэгжилтийг хангаагүй бол шалтгаан юу байв, яагаад гэдэг талбарыг дэлгэрэнгүй бичих

### 1.2. Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилт

№	Хаанаас ирсэн	Тушаал, албан тоотын нэр	Албан бичгийн огноо, дугаар	Хэрэгжилтийг нотлох баримт бүрэн эсэх /тайлан, илтгэх хуудас гэх мэт/ хэрэв хэрэгжилтийг хангаагүй бол шалтгаан юу байв, яагаад гэдэг талбарыг дэлгэрэнгүй бичих

### 1.3. Үндэсний төвийн захирлын тушаалын хэрэгжилт

№	Хаанаас ирсэн	Тушаал, албан тоотын нэр	Албан бичгийн огноо, дугаар	Хэрэгжилтийг нотлох баримт бүрэн эсэх /тайлан, илтгэх хуудас гэх мэт/ хэрэв хэрэгжилтийг хангаагүй бол шалтгаан юу байв, яагаад гэдэг талбарыг дэлгэрэнгүй бичих

### 1.4 Стандарт, зааврын хэрэгжилт

№	Стандарт, зааврын нэр тоот	Дугаар огноо	Хэрэгжилтийг нотлох баримт бүрэн эсэх /тайлан, илтгэх хуудас гэх мэт/ хэрэв хэрэгжилтийг хангаагүй бол шалтгаан юу байв, яагаад гэдэг талбарыг дэлгэрэнгүй бичих
1			

Хоёр. Хүний нөөцийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Үр дүн
	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь			
	Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал			
	Шагнал, урамшуулалд хамрагдсан байдал			
	Сэтгэл ханамжийн дүн			
	Ил тод байдал /хүний нөөцийн/			
Хүний нөөцийг хөгжүүлэх				
	Дотоод, гадаад сургалт			
	Мэргэшүүлсэн			
	Мэргэжил дээшлүүлсэн сургалт			
Ёс зүйн хийсэн үйл ажиллагаа				
	Байгууллагын хөгжил, соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагаа			

Гурав. Эрдэм шинжилгээ, судалгааны шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тоо	Үр дүн
1	Олон улсад итгэл хэлэлцүүлж, өгүүлэл хэвлүүлсэн байдал		
2	Дотоод илтгэл хэлэлцүүлж, өгүүлэл хэвлүүлсэн байдал		
3	Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэсэн байдал (батлагдсан арга зүй, удирдамж бүхий)		

Дөрөв. Сургалтын шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тоо	Үр дүн
1	Төгсөлтийн дараах сургалтын эмч, мэргэжилтнүүдийн хамрагдсан хувь		
2	Үндэсний төвөөс тухайн жилд зохион байгуулсан зайн сургалтад хамрагдсан байдал		

Тав. Цахим хуудас мэдээ, мэдээлэл нийтлүүлсэн байдал

№	Шалгуур үзүүлэлт	Тоо	Үр дүн
1	Мэдээ, мэдээлэл нийтлүүлсэн байдаг		
2	Зоонозын өвчнөөс урьдчилсан сэргийлэх чиглэлээр хүн амд болон эмнэлэгийн мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөгөө, сэрэмжлүүлэг, инфографик, сургалт, сурталчилгаа, тандалт, судалгааны талаар нийтлүүлсэн мэдээний эзлэх хувь		
3	Цахим хуудсанд байршуулах мэдээ, мэдээллийн шаардлагын дагуу мэдээнүүдээ бэлтгэн ирүүлж, шууд нийтлүүлсэн байдал		



Арав. Хүн амын дундах тандалт судалгааны шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тарваган тахал	Боом	Хачигт халдвар	Галзуу	Бусад халдвар	Тайлбар
1	Хүн амын дундах тандалт судалгаа	Асуумж судалгаагаар тогтоосон тухайн халдварын талаарх хүн амын мэдлэг хандлагын түвшин (%-иар)					
		Асуумж судалгаагаар тогтоосон тухайн халдварын талаарх эрсдлийн үнэлгээ (%-иар)					
		Хүн амын дундах зоонозын өвчний халдваржилтын хувь					
		Хүн амын дундах тандалт судалгааны дүгнэлт, зөвлөмж, эргэн мэдээлсэн байдал					
		Тайлан бичсэн байдал, зааврын хэрэгжилт, хугацаандаа илрүүлсэн эсэх					
2	Лабораторийн шинжилгээний дүн	Нийт цуглуулсан ийлдсийн тоо, үүнээс эерэг сорьцын тоо					

В/Тайлангийн бичиглэл

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Өмнөх онуудын тандалт судалгааны дүнд үндэслэсэн эсэх	
2	Тандалт судалгааны аргачлал	
3	Асуумж судалгааны боловсруулалт	
4	Дүгнэлт, тархвар судлалын эрсдлийг бууруулах талаар хүргүүлсэн зөвлөмж	
5	Өмнөх судалгааны дүнгээс мэдлэг, хандлага, эрсдлийн түвшин өссөн буурсан эсэх	
6	Эргэн мэдээлсэн байдал	
	Тайлангийн бичиглэл	

Арван нэг: Лабораторийн шалгуур үзүүлэлт

A/ Үндсэн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Нян судлал	Ийлдэс судлал	Биологи	Бусад арга	Шинжилгээний үр дүн	Үр дүн	Тайлбар
1	Байгалийн голомт хяналтын шинжилгээ	Тарваган тахлын байгалын голомт хяналтын шинжилгээ						
		Боомын байгалийн голомт хяналтын шинжилгээ						
		Хачигт халдварын голомт хяналтын шинжилгээ						
2	Тархвар судлалын заалтаар хийгдэх хяналтын шинжилгээ	Холер						
		Боом						
3	Хүн амын дунд хийгдсэн тандалт судалгаа	Тухайн өвчний нэрийг бичих						
4	Лабораторийн шинжилгээний баталгаажилт	Илэрсэн өсгөвөр						
		Эерэг сорьц						
5	Зоонозын хүний өвчний болон мэргэчийн дуудлагын тохиолдол	Тарваган тахал						
		Боом						
		Хачигт халдвар						
		Галзуу						
		Бусад						
		Мэргэчийн дуудлага						
6	49-р маягтын ерөнхий үзүүлэлт							

Б/ Лабораторийн хүний нөөц болон оношилгоог чадавхижуулах

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
1	Лабораторийн мэргэжилтний сургалт хангалт	Нян судлаач эмч		
		Лаборант		
2	Шинээр авсан лабораторийн тоног төхөөрөмж			
3	Тэжээлт орчин	Захиалсан		
		Авсан		
4	Оношлуур	Захиалсан		
		Авсан		
Лабораторийн хүний нөөцийн болон оношилгоог чадавхижуулах				

В/ Тайлангийн бичиглэл

Давуу тал	Сул тал	Цаашид

Арван хоёр: Ариутгал халдваргүйтгэл, хог хаягдлын менежмент үйл ажиллагааны шалгуур

№	Шалгаар үзүүлэлтүүд	Хэрэгжилт	Үр дүн	Тайлбар
1	Лабораторийн бэлтгэл ажлыг хангаж ажилласан байдал	Угаасаа шилэн эдлэл		
		Халдваргүйтгэсэн		
		Ариутгасан		
		Зөөлөн эдлэлийн бэлтгэл ажил		
		Цэвэрлэгээ үйлчилгээ		
2	Эрүүл мэндийн сайдын 158 дугаар тушаал болон төвийн Захирлын 2015 оны А/58 дугаар тушаалын хэрэгжилт	Хог хаягдлын ангилан ялгалт		
		Хог хаягдалыг түр хадгалах байртай эсэх		
		Хог хаягдлыг халдваргүйтгэж устгасан байдал		
3	Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэл хийсэн байдал	Хүн болон мэрэгчийн сэжигтэй дуудлаганд үйлчилсэн байдал		
		Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл, шавьжгүйтгэл мэрэгчгүйтгэл		
4	Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Эрүүл мэнд, спортын сайд нарын хамтарсан А/51-А/28/57 дугаар тушаалын хэрэгжилт			
5	Ариутгал халдваргүйтгэлд баримтлах эрх зүйн баримт бичгийн мөрдөх, анхан шатны бүртгэл маягт хөтлөх			



## ТАЙЛАН БИЧИХ ЕРӨНХИЙ АГУУЛГЫН ДАРААЛАЛ

### Нэг. Бүтэц зохион байгуулалт

- 1.1. Удирдлага зохион байгуулалт
- 1.2. Хүний нөөцийн менежмент
  - Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал
  - Шагнал урамшуулалд хамрагдсан байдал
  - Хүний нөөцийн ил тод байдал
- 1.3. Хүний нөөцийг чадавхижуулах сургалт
  - Үндсэн мэргэшлийн сургалт
  - Төрөлжсөн мэргэшлийн сургалт
  - Дагалдан сургалт
  - Давтан сургалт
- 1.4. Гадаад хамтын ажиллагаа
- 1.5. Ёс зүй болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- 1.6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт

### Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

- 2.1. Байгалын голомтын тандалт судалгаа
  - Тарваган тахал өвчний тандалт судалгаа
  - Хачгаар дамжих халдварын тандалт судалгаа
  - Шувууны тандалт судалгаа
  - Шумуулын тандалт судалгаа
  - Холер, боомын шинжилгээ
- 2.2. Байгалийн голомт хяналтын шинжилгээний үйл ажиллагаа
- 2.3. Хүн амын дундах тандалт судалгаа
  - Тарваган тахал өвчний тандалт судалгаа
  - Хачгаар дамжих халдварын тандалт судалгаа
  - Шувууны тандалт судалгаа
  - Шумуулын тандалт судалгаа
  - Боом өвчний тандалт судалгаа
- 2.4. Дархлаажуулалтын үйл ажиллагаа
  - Хамралтын хувь /Өвчнөөрөө/
  - Галзуугийн вакцины хамралт
  - Өмнөх онуудтай харьцуулсан байдал
- 2.5. Мэдээлэл, сургалт, сурталчилгаа
  - Телевизийн ярилцлага

- Радио ярилцлага
  - Цахим хэрэгсэл
  - Шинээр боловсруулсан инфографик, постер
- 2.6. Салбар хоорондын хамтын ажиллагаа

### **Гурав. Зоонозын халдварын хариу арга хэмжээ**

- 3.1. Дуудлагын бэлэн байдал
- 3.2. Амьтны дуудлага
- 3.3. Хүний дуудлага
- 3.4. Эрсдэлийн үнэлгээ
- 3.5. Хүний өвчлөлийн голомтод авсан хариу арга хэмжээ

### **Дөрөв. Лабораторийн үйл ажиллагаа**

- 4.1 Лабораторийн шинжилгээ, оношилгоо
  - Хүний онош тодруулах шинжилгээ, оношилгоо
  - Хот орчмын мэрэгч амьтны дуудлага
  - Захиалгат шинжилгээ
  - Хүн амын дундах тандалт шинжилгээ
  - Өсгөвөр эерэг сорьц баталгаажуулалт
  - Сэргийлэх шинжилгээ /Холер, боом/
  - Гадаад чанарын хяналт
- 4.2. Лабораторийн шинжилгээ оношилгооны бэлэн байдал
- 4.3. Бусад үйл ажиллагаа

### **Тав. Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээ**

- 5.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт
- 5.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн гүйцэтгэл
- 5.3 Стандарт, зааврын хэрэгжилт
- 5.4 Зоонозын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилт
- 5.5 Халдвар хамгаалал биоаюулгүй ажиллагаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

### **Зургаа. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагаа**

- 6.1 Судалгаа, шинжилгээний ажил
  - Боловсруулсан, хэрэгжүүлж буй болон орлосон төсөлт ажил, судалгааны ажил
  - Ажиллаж буй болон шинээр элссэн, хамгаалсан магистр, докторын мэдээлэл
- 6.2 Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн

- Үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд оролцсон байдал
- 6.3 Эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, өгүүлэл
- Үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байдал
  - Үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд оролцсон, илтгэл хэлэлцүүлсэн байдал
  - Хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн илтгэл, өгүүлэлд оролцсон байдал

### Долоо. Ариутгал халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа

7.1. Лабораторийн бэлтгэл ажлыг хангаж ажилласан байдал

7.2. Урьдчилан сэргийлэх, голомтын халдваргүйжүүлэлт, ахуйн шавж, мэрэгч устгал хийсэн байдал

7.3. Эмнэлгийн аюултай хог хаягдлын тоон мэдээний тайлан

7.4 .Хог,хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөө, тайлан

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

Д/д	Тайлангийн төрөл	Тайлан хүлээн авч нэгтгэх		Нэгтгэсэн тайланд ХШҮ хийх	
		Байгууллага, алба	Хугацаа	Байгууллага, алба	Хугацаа
Бодлогын баримт бичиг	МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"	ЗӨСҮТ, Захиргааны алба	VII.15	ЗӨСҮТ, Захиргааны алба	VII.22
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	ЗӨСҮТ, Захиргааны алба	V.15 XI.15	ЗӨСҮТ, Захиргааны алба	V.22 XI.22
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	МУ-ын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, ЗГ-ын шийдвэр	ЗӨСҮТ, Захиргааны алба	V.15 XII.16	ЗӨСҮТ, Захиргааны алба	V.22 XII.23
Төсөл	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	ЗӨСҮТ, Захиргааны алба	XII.23	ЗӨСҮТ, Захиргааны алба	I.06
Хүний нөөц	Эргэн мэдээлэл	ЗӨСҮТ, Захиргааны алба	I.15	-	-